



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАН ТАНД ХУУЛИАР ЮУГ ЗӨВШӨӨРЧ, ЮУГ ХОРИГЛОХ ВЭ?

■ Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?	3
■ Нийтийн албан тушаалтан гэж хэн бэ?	4
■ Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд	4
■ Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт	5
■ Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт	5
■ Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт	6
■ Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох	10
■ Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт	11
■ Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт	12
■ Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт	15
■ Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт	16
■ Хандив авахтай холбогдсон хязгаарлалт	21
■ Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт	24
■ Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам	28
■ Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт	28
■ Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт	32
■ Бусад орлогын хязгаарлалт	34

УЛААНБААТАР ХОТ
2012 ОН

DDC
354.98
A-427

**НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАН
ТАНД
ХУУЛИАР ЮУГ ЗӨВШӨӨРЧ,
ЮУГ ХОРИГЛОХ ВЭ?**

Хэвлэлд бэлтгэсэн: Т.МӨНХТҮНГАЛАГ
/Авлигатай тэмцэх газрын
Урьдчилан сэргийлэх, соён
гэгээрүүлэх хэлтсийн ажилтан/

Хянан тохиолдуулсан: Д.ДУЛАМСҮРЭН
/Авлигатай тэмцэх газрын
Урьдчилан сэргийлэх, соён
гэгээрүүлэх хэлтсийн дарга/

Хэвлэгдсэн хугацаа: 2012 оны 4 дүгээр сар

© Авлигатай тэмцэх газар, 2012 он

Ашиг сонирхлын зөрчил гэж юу вэ?

Ашиг сонирхлын зөрчлийн тухай авч үзэхийн өмнө нийтийн ашиг сонирхол ба хувийн ашиг сонирхлын талаар тодорхой ойлголт өгөх нь зүйтэй. Нийтийн албананд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд тайлбарласнаас үзэхэд, нийтийн ашиг сонирхол гэдэг нь нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ хэмээн олон нийтийн итгэлийг хэлдэг. Тэгвэл хувийн ашиг сонирхол гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг ойлгоно хэмээн хуульд тодорхойлжээ.



Тухайн албан тушаалтны албан үүргээ шударгаар гүйцэтгэнэ гэх олон нийтийн итгэлийг хөсөрдүүлж, хувийн ашиг сонирхлоо эрхэмд үзэх хандлагыг ашиг сонирхлын зөрчил хэмээн энгийнээр тайлбарлаж болох юм. Нийтийн албананд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд “ашиг сонирхлын зөрчил гэж нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц байдлыг” хэлнэ хэмээн тодорхойлсон.

Нийтийн албан тушаалтан гэж хэн бэ?

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /цаашид “Хууль” гэх/-ийн 4 дүгээр зүйлд нийтийн албан тушаалтан буюу энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг заасан байна.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэлд хамаарах этгээд

4.1.Дор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна:

4.1.1.төрийн улс төрийн, захирагааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан;

4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан;

4.1.4.хууль тогтоомжийн дагуу, эсхүл улсын болон орон нутгийн төсвээс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.5.энэ хуулийн 23.1-д заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалтын жагсаалтад орсон албан тушаалтан.



Нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт



10 дугаар зүйл. Албаны мэдээллийг ашиглахтай холбогдсон хориглолт

10.1. Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгт нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.



Жишээ 1. Засгийн газрын нэгэн агентлагийн удирдах албан тушаалтан Хонгор өөрийн чиг үүргийн хурээнд “Өрнө-Дорно” банк дампуурах гэж байгааг олж мэдэн тус банкинд их хэмжээний хадгаламж эзэмшдэг өөрийн нایз Готовт мэдээлэл дамжуулсан байна. Готовт банкнаас хадгаламжаа татах авсан бөгөөд банк дампуурахад тэрээр ямар ч эрсдэл хүлээгээгүй аж.

Албан тушаалтан Хонгор Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг зөрчиж бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулжээ.

Жишээ 2. Төрийн өмчийн уул уурхайн нэгэн томоохон компанийн өөрөө буулгагч автомашины хөдөлгүүрийн эд анги эвдэрснээс болж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох болов. Тиймээс уг автомашинд зориулсан эд ангийг худалдан авах тендерийг зарлахаар тогтжээ. Компанийн гүйцэтгэх захирад Донров энэ тухай мэдээллийг их сургуулийн нایз Сүрэндээ хэлэв. Ингэснээр нایз Сүрэн нь өөрөө буулгагч автомашины хөдөлгүүрийн эд ангийг нийлүүлэх тендерт оролцох боллоо. Худалдан авах ажиллагааны үе шат бурийг /босго үнэ, оролцогчдын санал, тоо г.м нийтэд тодорхой болсноос бусад бүх мэдээллийг/ найздаа мэдээлж, тухайн нөхцөл байдалд тохирсон зөвлөгөөг бас өгч байв. Энэ бүхний үр дүнд Сүрэнгийн хувийн компаниас технологийн хувьд хуучирсан, дахин ашиглахаа больсон эд ангийг нийлүүлжээ.

Гүйцэтгэх захирад Донров бүрэн эрхийнхээ хүрээнд олж авсан мэдээллийг задруулснаар нایз Сүрэндээ ашигтай байдал үүсгэсэн байна.

Жишээ 3. Нэгэн дүүргийн газрын албаны дарга Батад удахгүй батлах газар зохион байгуулалтын ойрын таван жилийн өрөнхий төлөвлөгөөнд санал авах албан бичгийг төлөвлөгөөний төслийн хамт ирүүлжээ. Төсөлд тухайн дүүргийн иргэдийн өмчлөл болон эзэмшилд ороогүй газрууд багтсан байв. Бат үүний сорогоор тусган авч, өөрийн болгохоор төлөвлөж байсан газрыг төрсөн дүү Хүрлээд хэлж, яялтай хөөцөлдөн авахыг санал болгов. Төлөвлөгөө ч Батын өгсөн саналын хүрээнд дэмжигдэн батлагдаж, өөрийн дүү Хүрлээтэй хэлэлцэн ёсоор хүссэн газраа өөрсдийн эзэмшлийн болгож чадлаа.

Бат өөрт олдсон эрх мэдлийн хүрээнд олж авсан мэдээллийг хамаарал бүхий этгээдэд давуу байдлаар олгож, улмаар хууль зөрчсөнийг дээрх жишээ харуулж байна.

11 дүгээр зүйл. Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалт

11.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг

хөндсөн захирагааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явулахыг хориглоно.



Жишээ 4. Нэгэн аймгийн мэргэжлийн хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч Намсрай нь тухайн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг хариуцдаг. Гэтэл түүний эхнэр Туяа “Шимт-Ус” нэртэй ундааны цех ажиллуулдаг байна. Намсрай нь талх, ундаа үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдэд шалгалт хийх удирдамжийн төслийг өөрөө гардан боловсруулав. Түүнчлэн хяналт шалгалтын ажлын хэсгийг биечлэн удирдахаар уг удирдамжид тусгажээ. Батлагдсан удирдамжийн дагуу Намсрай хяналт шалгалтын ажлыг хийв. Шалгалтын дүнг нэгтгэх, хэлэлцүүлэх, шийдвэр гаргах үе шатуудад ч мөн оролцсон байна. Шалгалтын үр дүнд үндэслэн зарим аж ахуйн нэгжүүдэд хариуцлага тооцох шийдвэрийг ч гаргалцав. Харин түүний эхнэр Туяагийн удирддаг ундааны цех шалгалтад “маш сайн” дүн үзүүлжээ.

Намсрай эхнэрийнхээ ажиллуулдаг аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийх ажилд оролцохос татгалзах учиртай байсан. Эхнэр нь хамаарал бүхий этгээд учраас түүний ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гаргахад оролцож, хянан шалгасан нь хууль бүс үйлдэл юм.

Жишээ 5. Засгийн газрын нэгэн хэрэгжүүлэгч агентлагт өөрийн эзэмшилэн мэргэжлийн чиглэлээр ажлын байр зарлагдсаныг иргэн Цэцэг үзээд зохих шалгалтыг өгч тэнцлээ. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн Цэцэгийг томилиуулах албан бичгийг тухайн агенлагийн дарга Сүрэнд явулав. Сүрэн дарга албан бичгийг аваад өөрийн төрсөн эгчийн охин байхыг мэдсэн тул Цэцэгийг ажилд томилох шийдвэрийг гаргасангүй.

Энэ тохиолдолд Сүрэнг сайшаах нь зүйтэй. Учир нь тэрээр хуулиа дээдлэн ашиг сонирхлын зөрчилд өртөхөөс сэргийлж ажилласан байна.

11.2. Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашигийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захирагааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.



Жишээ 6. Мөнхөө “Их хотын барилга” ХХК-д инженерээр ажиллаж байгаад 2011 оны 9 дүгээр сард Барилгын яамны Хот төлөвлөлтийн хэлтэст мэргэжилтэн болов. Туунийг хэлтсийн дарга нь Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд нэр бүхий барилгын компаниудтай гэрээ байгуулан ажиллахыг үүрэг болгожээ. Мөнхөө барилгын компаниудын дотор өөрийнх нь ажиллаж байсан “Их хотын барилга” ХХК орсон байв. Мөнхөө Нийтийн албандаа нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасныг баримтлан энэ ажлаас татгалзав. Яагаад гэвэл барилгын компаниудтай гэрээ байгуулах хугацаа нь 2012 оны 6 дугаар сард таарч байв.

Мөнхөөгийн өмнө ажиллаж байсан “Их хотын барилга” ХХК нь түүний нэгдмэл сонирхолтой этгээд бөгөөд тэд ашигийн төлөө үйл ажиллагаа явуулж байсан. Мөнхөө 2012 оны 9 дүгээр сарыг дуустал өмнө ажиллаж байсан байгууллагатай холбоотой ямар нэгэн үйл ажиллагаа явуулах учиргүй. Ийм тохиолдолд Мөнхөөгийн гаргасан шийдвэр хуульд нийцсэн бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсгэхээс урьдчилан сэргийлсэн алхам болж байна.

Жишээ 7. Болд “Мөнгөн тулга” банк бус санхүүгийн байгууллагыг байгуулан захирлаар нь 2 жил ажиллаж байгаад Санхүүгийн зохицуулах хорооны хэлтсийн даргаар томилогдов. Ажлаа аваад хагас жил болж байтал банк бус санхүүгийн байгууллагуудыг шалгах Хорооны даргын шийдвэр гарчээ. Шийдвэрт Болдын шалгах хуваарыт байгууллагуудын жагсаалтад “Мөнгөн тулга” банк бус санхүүгийн байгууллага орсон байв. Болд хяналт шалгалтын хуваарыт өөрчлөлт оруулахыг хүссэнгүй.

Болд шинэ албанад томилогдоод хагас жилийн хугацаа өнгөрч байгаа тул өмнө ажиллаж байсан байгууллагыг хяналт шалгах ёсгүй бөгөөд өөрт нь оноосон хяналт шалгалтын хуваариас “Мөнгөн тулга” банк бус санхүүгийн байгууллагыг хасуулах учиртай юм.

11.3. Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдооюусоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанад орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны акт гаргахыг хориглоно.



Жишээ 8. Газар тариалан эрхэлдэг “Арвин ургац” ХХК-ийн хяналтын зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаад 2010 оны 11 дүгээр сард Хөдөө аж ахуйн яамны харьяа агентлагийн даргаар томилогдсон Аюуш 2012 оны 7 дугаар сарын 3-ны өдөр өөрт олгогдсон албаны эрх мэдлээ ашиглаж, өмнө нь ажиллаж байсан “Арвин ургац” ХХК-д төсвөөс их хэмжээний мөнгөн дэмжлэг олгох сонирхлын зөрчилтэй шийдвэрийг гаргасны улмаас төрийн албанаас халагдсан байна.

Аюуш 2012 оны 11 дүгээр сарыг дуустал “Арвин ургац” ХХК-ийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны акт гаргах ёсгүй байсан.

11.4. Энэ хуулийн 11.3-т заасан захиргааны акт гаргах хязгаарлалт нь төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан албан тушаалтанд хамаарахгүй.

Жишээ 9. Саран “Монгол шуудан” төрийн өмчит ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаад жилийн дараа Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны хэлтсийн даргаа томилогджээ. Сарангийн хариуцсан салбарын чиглэлээр зарласан тендерийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог ахалж ажиллан гүйцэтгэгчээр “Монгол шуудан” төрийн өмчит компани шалгарав.

Сарангийн үйлдэл хууль зөрчөөгүй байна.

12 дугаар зүйл. Шийдвэр гаргахад нөлөөлөхийг хориглох

12.1. Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны акт гаргах, удирдах, хяналт, шалгалаат хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.



Жишээ 10. Нэгэн аймгийн хэмжээнд Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтсийн хамтарсан ажлын хэсэг Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд удаа дараагийн зөрчил дутагдал гаргадаг, байнга цаг хэтрүүлэн ажилладаг Наран эзэнтэй “Fire” баарны үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хураан авч, хаалгыг лацдаж байх үед мэргэжлийн хяналтын байцаагч руу хэлтсийн дарга нь утасдаж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг эргүүлж өгөх үүрэг өгсөн байна. Ингэснээр Саран уг баарны зөвшөөрлийг буцаан өгчээ.

Энэ тохиолдолд хэлтсийн дарга шийдвэр гаргахад хөндлөнгөөс нөлөөлж, Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг зөржжээ.

Жишээ 11. Хотын төвийн дүүрэг дэх “Өнөр” зоогийн газрын эзэн Алимаагийн нөхөр Юндэн нь нийслэлийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалтай. Төвийн дүүрэгт ажиллаж буй зоогийн газруудад тухайн дүүргийн Үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсээс төлөвлөгөөт шалгалт явуулахад “Өнөр” зоогийн газарт стандартын шаардлага хангаагүй, эрүүл ахуйн наад захын горимыг мөрдөөгүй зэрэг хэд хэдэн зөрчил илэрчээ. Шалгалтын дүнг нэгтгэн боловсруулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлан, мэргэжлийн хяналтын байгууллагад уламжлахаар зэхжэй байх явцад Юндэн дүүргийн хэлтсийн дарга Сумъяа руу утасдаж, “Өнөр” зоогийн газарт холбогдох хэсгийг шалгалтын тайлангаас хасахыг үүрэгдсэн байна. Гэвч дүүргийн дарга Сумъяа шалгалтын тайлангаас “Өнөр” зоогийн газрын нэрийг хасуулсангүй.

Юндэн өөрийн албан тушаалтын байдлаа ашиглан эхнэрийнхээ ажиллуулдаг зоогийн газарт илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр хариуцлага тооцох тухай шийдвэрийг гаргуулахгүй байхад нөлөөлөхөөр хуулийн заалтыг зөрчсөн байна.

13 дугаар зүйл. Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт
13.1. Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалтын байдлаа ашиглан оролцохыг хориглоно.



Жишээ 12. Харилцаа холбооны зохицуулах хорооны хэлтсийн дарга Цэрэн нь нэгэн үүрэн телефоны оператор компанийн хэрэглэгчдэд шинээр санал болгож байгаа дэвшилтэт технологийн бүтээгдэхүүн үйлчилгээний сурталчилгаанд оролцож, мэргэжилтний хувьд саналаа илэрхийлэв.

Цэрэн харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ижил тэгш харилцах учиртай. Гэтэл тэрээр зөвхөн нэг компанийн үйлчилгээг ийнхүү танилцуулсан нь албаны нэр хүндээ ашиглан аливаа зар сурталчилгаанд оролцохыг хориглосон заалтыг зөрчсөн хэмээн ойлгогдоно.

Жишээ 13. Нэгэн дүүргийн Онцгой байдлын хэлтсийн олон нийттэй харилцах тасгийн дарга, “Оны шилдэг залуу”-гаар шалгарсан Амар “Онцгой байдлын үед иргэн та юу хийх вэ?” арга хэмжээний үр дунгийн талаарх ээлжит мэдээллийг телевизээр хийжээ. Энэ мэдээллийг сонссон нэгэн иргэн “Манай байгууллага аврах тусгай хэрэгслийн тоног төхөөрөмж нийлүүлдэг юм. Танай байгууллагаас зохион байгуулдаг телевизийн нэвтрүүлгийн дундуур танаар сурталчилгаа хийлгэе” гэсэн санал тавьжээ. Амар ингэх нь төрийн байгууллагын ажилтны хувьд хуулиар хориглосон үйл ажиллагаа болохыг иргэнд тайлбарлан өгсөн байна.

Амар өөрийн хариуцсан үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлсэн. Хэдийгээр аврах тусгай хэрэгслийн тоног төхөөрөмж нь аврах албаны үйл ажиллагаанд тустай боловч тэдгээрийг сурталчлах нь тухайн тоног төхөөрөмжийг нийлүүлдэг байгууллагын ашигийн төлөөх үйл ажиллагаанд хамаатай тул энэ талын сурталчилгаанд оролцоогүй Амарын үйлдэл хуульд нийцэж байна.


13.2. Энэ хуулийн 13.1-д заасан хязгаарлалт нь Улсын Их Хурлын гишүүний болон Засгийн газрын гишүүний нийгэмд тустай үйл ажиллагааны сурталчилгаанд оролцоход хамаарахгүй.

Жишээ 14. Татварын улсын ахлах байцаагч Доржийг “Нийслэлийн хүндэт иргэн” шагналаа аваад удаагүй байхад татвар бүрдүүлэлтэй холбоотой 1 минутын сурталчилгаанд тоглохыг дарга нь хүсчээ. Дорж амжилттай сайн тоглосон учир тэр даруйдаа сурталчилгааны нэгэн агентлагаас сурталчилгаанд тоглох хоёр санал ирэв. Нэг нь “Залуус аа, хог бүү хаяарай” гэсэн нийгмийн шинж чанартай сурталчилгаа, нөгөө нь татвараа хуулийн дагуу төлж, нийгмийн хариуцлагаа ухамсарладаг “Очис” компанийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах санал байв. Татварын улсын ахлах байцаагч Дорж дээрх хоёр саналаас шууд татгалзжээ. Харин сурталчилгааны агентлаг “Залуус аа, хог бүү хаяарай” сэдэвт сурталчилгаанд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдийг тоглуулсан байна.

Дорж хууль зөрчөөгүй. Тэрээр албан үүрэгтээ хамаарах асуудлаар сурталчилгаанд оролцсон, харин өөр бусад төрлийн сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцох учиргүй. Харин нийгэмд тустай үйл ажиллагааны сурталчилгаанд Улсын Их Хурлын гишүүд оролцохыг зөвшөөрсөн байна.

14 дүгээр зүйл. Төлөөлөлтэй холбогдсон хязгаарлалт
14.1. Албан тушаалтан нийтийн албыг өөрийн хувийн ашиг

сонирхлын өмнө төлөөлөхийг хориглоно.



Жишээ 15. Нэгэн дүүргийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Энхжин нь дүүгийнхээ “Энх саруул” нэртэй эмийн сангийн үйл ажиллагааг дэмжиж дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн зохион байгуулж буй хуралд ирж оролцжээ. Ингэхдээ дүүргийн харьяа эмнэлгүүдийнхээ удирдлагад тус дүүргийн эмнэлэг, оношилгооны төвүүдээр үйлчлүүлж байгаа бүх иргэдэд “Энх саруул” эмийн сангийн эм, эмийн бүтээгдэхүүнийг санал болгож байхыг үүрэг болгосон байна.

Төрийн сангийн хэлтсийн дарга Энхжин өөрийн хашиж буй албан тушаалтыг ашиглан дүүгийнхээ буюу хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлын өмнө нийтийн албыг төлөөлсөн байна.

Жишээ 16. Нэгэн дүүргийн газрын албаны дарга Самдангийн эхнэрийн “XXX” компанийн газрын төлбөр нь 10 сая төгрөг болжээ. Гэтэл албаны дарга Самдан газрын төлбөрөөс чөлөөлөх тухай тушаал гаргажээ. Уг тушаалд “Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн “XXX” компанийг газар ашиглах гэрээ болон газар ашиглах эрхийн гэрчилгээнд заасан хэмжээний газрын төлбөрөөс чөлөөлсүгэй” гэсэн байна.

Самдан нийтийн албыг өөрийн хувийн ашиг сонирхлын өмнө төлөөлж, хууль зөрчсөн гэж ойлгогдож байна.

14.2. Албан тушаалтан албан үүрэгтэй нь шууд ба шууд бусаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бусад этгээдийн өмнө төлөөлөхийг хориглоно.



Жишээ 17. Хятад улсын хөрөнгө оруулалттай газрын тосны олборлолт явуулдаг “Янтуунх” компанийн үйл ажиллагаатай танилцах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгахаар ажиллаж байгаа Засгийн газраас томилогдсон ажлын хэсгийн даргатай уг компани нутаг дэвсгэр дээр нь үйл ажиллагаа явуулдаг, харьяанд нь ажилладаг албан тушаалтнууд хяналт тавьдаг сумын Засаг дарга Самбуужав уулзаж “Янтуунх” компани нь сум орны хөгжилд ихээхэн хөрөнгө оруулалт хийж байгааг танилцуулахын сацуу тус компаниас гарч байгаа бүтээгдэхүүний зардлыг бууруулах үүднээс өөрийн суманд хилийн боомт нээх хүсэлтийг дээд шатны байгууллагад уламжлахыг хүсчээ.

Сумын Засаг дарга Засгийн газраас томилогдсон ажлын хэсгийн даргад хууль бус хүсэлтийг тавьсан байна.

Жишээ 18. Нэгэн дүүргийн замын цагдаагийн хэлтсийн тасгийн дарга Яримпилын эхнэр жолооны курс байгуулахаар болжээ. Эхнэр нь жолооны курс байгуулах зөвшөөрөл гаргуулж өгөхийг Яримпилаас хүссэний дагуу тэрээр Замын цагдаагийн газрын жолооны курс хариуцсан нэгжийн даргатай уулзаж, бүрдүүлсэн материалыа гардуулан эхнэрийнхээ ажиллуулах жолооны курсын зөвшөөрлийг түргэн хугацаанд гаргаж өгөхийг гүйжээ.

Энэ тохиолдолд Яримпил өөрийнхөө албан үүрэгт шууд холбогдох байдлаар эхнэрээ Замын цагдаагийн газрын нэгжийн даргын өмнө төлөөлсөн гэж ойлгогдож байна.

14.3. Албан тушаалтан дараах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өмнө нийтийн албыг төлөөлж болохгүй:

- 14.3.1. өөртэй нь хамаарал бүхий этгээдийн өмнө;
- 14.3.2. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь

ашиг хүртдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө;

14.3.3. албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захирагааны ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын өмнө.

Жишээ 19. Засгийн газрын нэгэн агентлагийн хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн Төрөө өөрийн байгууллагын албан хаагчдад англи хэлний хичээл заалгахаар хэлний сургалтын төвүүдийн байршил, сургалтын унэ болон бусад мэдээллийг цуглуулан судалж үзээд нэгэн сургалтын төвийг сонгож биечлэн уулзаж, гэрээ хийхээр болсон байна. Энэ талаар удирдлагадаа танилцуулахад сургалтыг зохион байгуулахыг зөвшөөрөөд байгууллагыг төлөөлж сургалтын төвтэй гэрээ байгуулах эрхийг агентлагийн эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Шагдарт олгов. Шагдар сургалтын төвийн талаарх мэдээлэлтэй танилцаад уг гэрээнд сургалтын төвийн өмнө байгууллагаа төлөөлөх боломжгүй гэдгээ мэдэгдлээ. Учир нь сургалтын төвийн ерөнхий нягтлан бодогч нь түүний эхнэрийн дүү байв.

Сургалтын төвийн ерөнхий нягтлан бодогч нь Шагдартай хамаарал бүхий этгээд байсан тул тэрээр байгууллагаа төлөөлөн гэрээ байгуулахаас татгалзсан байна. Ингэснээр албан тушаалтан өөртэй нь хамаарал бүхий этгээдийн өмнө нийтийн албыг төлөөлж болохгүй гэсэн хуулийн заалтыг Шагдар биелүүлжээ.

15 дугаар зүйл. Төлбөр авахтай холбогдсон хязгаарлалт

15.1. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэсний төлөө аливаа төлбөр авахыг хориглоно.



Жишээ 20. Нэгэн яамны санхүүгийн хэлтсийн дарга Жавзан яамных нь өргөтгөлийг хийж дуусгасан “Си энд Ю” компанийн санхүүжилтийг З хоногийн дотор шийдвэрлэх үүргийг гэрээгээр хүлээсэн байв. Гэтэл Жавзан уг компанийн удирдлагад хандан, санхүүжилтийг шийдвэрлэхээс өмнө бичиг баримтын зардал гэх 50 мянган төгрөгийг яамны дансанд хийхийг шаарджээ.

Жавзан албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэсний төлбөө ямар нэгэн байдлаар төлбөр авах учиргүй тул хууль зөрчжээ.

15.2.Хууль тогтоомжоор болон Засгийн газар, орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлбөр авахаар тогтоосон бол нэмэлт төлбөр авахыг хориглоно.

Жишээ 21. Говь-Алтай аймгийн англи хэлний гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн захирал Өнөрмаа нь тус сургуулийн 3-10 дугаар ангийн сурагчдын түвшин тогтоо шалгалтын сорилын хураамж 2500 төгрөгийг “Сургууль хөгжүүлэх сан”-гийн дансанд тушаах тухай тушаал гаргасныг холбогдох байгууллага шалгаад хүчингүй болгосон байна.

Захирал Өнөрмаагийн тушаалаар нэмэлт төлбөр авах ёсгүй.

Жишээ 22. Нэгэн сумын ойн тасгийн дарга Билэгтээс тухайн сумын иргэн Амгалан мод бэлтгэх зөвшөөрөл авахаар хүсэлтээ гаргажээ. Тэрээр 4 шоо метр улиас мод бэлтгэх зөвшөөрлийг журмын дагуу нийтдээ /нэг шоо метр нь 3300 төгрөг/ 13200 төгрөг төлөх ёстойгоо мэдэж байв. Түүнчлэн улсын тэмдэгтийн хураамж болох 1300 төгрөг хураалгах учиртай. Амгалан 14500 төгрөг барьсаар сумын захиргаа руу явж очиход ойн тасгийн дарга Билэгт албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлүүлэх 500 төгрөг бэлнээр өгөхийг шаарджээ.

Албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлүүлэх 500 төгрөг авах тухай ойн тасгийн дарга Билэгтийн шаардлага хууль бус юм.

16 дугаар зүйл. Бэлэг авахтай холбогдсон хязгаарлалт

16.1.Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бусдаас бэлэг шууд буюу шууд бусаар авахыг хориглоно.



Жишээ 23. Хандгайтын Мөнгөний орд газрыг эзэмшдэг төрийн өмчит “Sil-Mon” компанийн ТҮЗ-ийн даргыг улируулан сонгох эсэх асуудлыг хэлэлцэхээр ТҮЗ-ийн гишүүдийг хурлын танхимд орж ирцгээхэд гишүүд тус бүрийн суудал дээр ТҮЗ-ийн дарга мэндчилгээний хамт мөнгөн эдлэл тавьсан байх бөгөөд энэхүү “гэнэтийн бэлэг” нь ямар учиртай дохио болохыг ойлгосон гишүүд санал нэгтэйгээр Эрдэнэбатыг улируулан сонгосон байна. Үүнийг нь Эрдэнэбат өгөөмөр үнэлж, гишүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх нэрийдлээр гишүүд тус бүрт компанийн хөрөнгөөр тохилог орон сууцыг 50 хувийн хөнгөлөлттэйгээр худалдан авахаа нөхцөл бүхий эрхийн бичгийг санал болгожээ.

Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хууль зөрчсөн. Тэд Эрдэнэбатаас шууд ба шууд бус хэлбэрээр бэлэг, үнэт зүйл авсан байна.

Жишээ 24. Эрчим хүчний яамнаас 5000 ширхэг нарны зайн нийлүүлэх тендерийг зарлажээ. Тендерт оролцож буй “Бодлын гэгээтэй” ХХК нэг ширхэг нарны зайн үнийг 200 000 төгрөгөөр, харин “Мөнхийн галт” ХХК 250 000 төгрөгөөр нийлүүлэх үнийн санал тус тус ирүүлсэн байв. Хуулийн дагуу хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Бодлын гэгээтэй” ХХК тендерт шалгарчээ. “Бодлын гэгээтэй” ХХК-ийн гүйцэтгэх захидал тендерийн хорооны гишүүдэд баярласнаа илэрхийлж, хүн тус бүрт гарын бэлэг хэмээн гадаадын өндөр үнэтэй архийг сувилалд амрах эрхийн бичгийн хамт өгсөн байна. Тендерийн хорооны гишүүд уг бэлгийг хүлээн авч, заримынх нь гэр бүл сувилалд амарчээ.

Эрчим хүчний яамны тендерийн хорооны гишүүд албан ўүргээ гүйцэтгэсэнтэй холбогдуулан “Бодлын гэгээтэй” ХХК-аас бэлэг, үйлчилгээ авах учиргүй бөгөөд харин ч тухайн бэлэг, үйлчилгээнээс татгалзах ёстой.

16.2. Энэ хуулийн 16.1-д заасан хориглолтод албан тушаалтанд албан ўүрэгтэй нь холбогдолгүй өгсөн бэлэг болон албан ўүрэгтэй нь холбогдуулан дипломат журмаар өгсөн бэлэг хамаарахгүй.



Жишээ 25. Хяналт шалгалтын ажлаар нийслэлээс аймгийн төвд ирж томилолтоор ажиллаж байсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн шалгалтын ажлаа дууссан өдрийн орой нь зочид буудалдаа ирэхэд буудлын жижүүр дээр хүн тус бүрийн тоогоор цаасан хайрцагтай зүйл үлдээж, бэлэг гэж хэлээрэй гэсэн байв. Буудлын жижүүр үлдээсэн хүний нэрийг хэлсэн боловч ажлын хэсгийнхэн нэг нь ч танихгүй байв. Тиймээс хоорондоо ярилцаад тэдний хийсэн шалгалттай холбоотой байж болзошгүй тул тэдгээрийг авахгүй байхаар шийдэж энэ тухай нийслэл рүү удирдлагадаа мэдэгдэхээр боллоо. Удалгүй үлдээсэн хүн өөрөө ирснээр ямар учиртай болох нь тодорхой болсон тул бэлгийг авсан байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд баярласан жолооч тэдэнд хувийн зүгээс бэлэг өгсөн байжээ.

Энэ нь албан үүрэгтэй нь холбогдуулан өгсөн бэлэгт хамаарахгүй тул ажлын хэсгийн гишүүд авч болно.

16.3. Албан тушаалтан дипломат журмаар бэлэг авах, тайлagnaх, зарцуулах журмыг Засгийн газар батална.

16.4. Гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны турван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

Жишээ 26. Төрийн албан хаагч Туяагийн багын найз Тунгаа хувиараа бизнесээрхэлдэг. Төрсөн өдрөөр нь Тунгаа найз Туяадаа 800.000 төгрөгийн үнэтэй гар утас бэлэглэв. Дээрх бэлэг нь Туяагийн нэг сарын цалингаас 2 дахин үнэтэй тул Туя хуулиар хүлээсэн үргийнхээ дагуу байгууллагынхаа эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд бичгээр мэдэгдсэн байна.

Энэ тохиолдолд Тунгаа нь Туяагийн төрөл, садангийн хүнбиш. Тиймээс Туяа бэлгийг эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор заавал мэдэгдэх үүрэгтэй. Тэрээр хуулиар хүлээлгэсэн үргээ биелүүлсэн байна.


16.5. Албан тушаалтны авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны зургаан сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд түүнийг төрийн өмчид шилжүүлнэ.

Жишээ 27. Иргэн Болор Боловсролын яаманд ажилладаг нийз Чимгээдээ албан тушаал дэвшсэнд нь баяр хүргэж, эрдэнийн чулуун шигтгээ бүхий цаг бэлэглэв. Цагны үнийн дүн түүний албан тушаалын б сарын цалингийн хэмжээнээс хэтэрсэн тул хууль, холбогдох журмын дагуу түүнийг төрийн өмчлөлд шилжүүлэв.

Чимгээ хуульд заасны дагуу цагийг төрийн өмчлөлд шилжүүлэх нь зөв.

Тайлбар: Төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг хэрхэн үнэлэх, зарцуулах, тайллагнах журмыг Засгийн газраас баталсан журмаар зохицуулдаг.

16.6. Албан тушаалтан зургаан сарын цалингийн хэмжээнээс илүү гарсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсний зөрүүг өөрөө төлж тухайн бэлэг, үйлчилгээг хүлээн авч болно.



Жишээ 28. Чимгээ төрийн өмчлөлд шилжүүлсэн цагны үнэ болон түүний 6 сарын цалингаас хэтэрсэн үнийн дүнгийн зөрүүг төлж цагийг өөртөө үлдээжээ.

16.7. Албан тушаалтан бэлэг авахаас өмнөх хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг тухайн бэлэг өгөгч этгээдээс албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно.

Жишээ 29. Чимгээ хоёр жилийн хугацаанд найз Болортойгоо холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлсэн бол түүнийг Болороос албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсанд тооцно.

16.8. Энэ хуулийн 16.4-т заасан этгээдээс бэлэг авсан бол албан тушаалтан тухайн этгээдтэй холбогдох захиргааны акт гаргах, удирдах, хянах, шалгах, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүргийг хоёр жилийн хугацаанд гүйцэтгэхгүй.



Жишээ 30. Боловсролын яамны мэргэжилтэн Чимгээ Японы Засгийн газрын тэтгэлгээр суралцах оюутнуудыг сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллав. Энэхүү сонгон шалгаруулалтад найз Болороогийн хүү оролцохоор бүртгүүлсэн байжээ. Гэвч Чимгээ уг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах комисст ажиллаж ажлаа дуусгажээ.

Найз Болороосоо хувийн журмаар албан үүрэгтэйгээ холбогдолгүй бэлэг хүлээн авсан Чимгээгийн хувьд хоёр жилийн хугацаанд бэлэг өгөгч этгээдтэй холбогдох захиргааны акт, удирдлага, хяналт, шалгалт, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг албан үүрэг хэрэгжүүлэх ёсгүй. Хэрэв эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлбэл өмнө нь найзаасаа авсан бэлгийг албан үргээ гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг авсан гэж үзнэ гэж дээр дурдсан. Иймд Шүүгч Хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-т заасны дагуу Чимгээгээр хүлээн авсан бэлэгний унийг төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тортожээ.

16.9. Төрийн болон орон нутгийн өмчтэй хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгч албан тушаалтан нь тухайн хуулийн этгээдэд ажиллах хугацаандаа, түүнчлэн албан үүргээ гүйцэтгэж дууссанаас хойш хоёр жилийн хугацаанд тухайн хуулийн этгээд, түүний удирдлагын гишүүдээс бэлэг авахыг хориглоно.

Жишээ 31. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн Гарамсүрэн “Санхүүгийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулж, цайллага хийх үед орон нутгийн өмчийн оролцоотой “ААА” компанийн удирдлага түүнд бэлэг гардуулахдаа бэлэгний үнийг уг компанийн хувь эзэмшигч хувийн компани төлсөн тул хуульд харшлахгүй байх гэж тайлбарлажээ. Гарамсүрэн “ААА” компанийн орон нутгийн өмчид ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгчөөр ажиллаж байгаад жилийн өмнө уг үүргээс чөлөөлөгдсөн юм байна. Тиймээс Гарамсүрэн бэлэгнээс татгалзсан бөгөөд хэдийгээр бэлэгний үнийг компанийн хувь эзэмшигч хувийн компани төлсөн боловч бэлгийг “ААА” компанийн нэрийн өмнөөс өгч байгаа, түүнчлэн бэлэг өгч байгаа талын төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгчөөр өмнө нь ажиллаж байсан тул авах боломжгүй гэдгээ хэлэв.

Гарамсүрэн нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төрд ногдох хувийг эзэмшигчийн төлөөлөгчөөр ажиллаж байсан. Одоо төрийн албанад ажиллаад 1 жил болж байгаа. Тиймээс “ААА” компанийн удирдлагаас хоёр жилийн дотор бэлэг авч болохгүй бөгөөд тэрээр хуульд заасан хориглолтыг зөрчөөгүй байна.

16.10. Албан тушаалтны төрийн өмчлөлд шилжүүлсэн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлсийг үнэлэх, хадгалах, зарцуулах журмыг Засгийн газар батална.

16.11. Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх шагналыг энэ хуулийн 16.1-16.10-т заасан журмаар зохицуулна.

17 дугаар зүйл. Хандив авахтай холбогдсон хязгаарлалт

17.1. Албан тушаалтан, төрийн болон нутгийн захирагааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно.



Жишээ 32. Сургуулийн барилга барих тендер шалгаруулалтыг зохион байгуулж буй ажлын хэсэг уг үйл ажиллагаатай холбогдох гадаад орны туршлага судлах зорилгоор мэдээлэл олж авах гэтэл ажлын хэсгийн байрлаж буй газрын албан өрөөнд интернэтийн сүлжээ ороогүй байв. Иймд ажлын хэсгийнхэн ажлын хэсгийн гишүүдийн хэрэгцээнд модем авч өгөхийг хамтран ажилладаг хуулийн этгээдээс хүсчээ.

Тендер шалгаруулах комиссын гишүүд нь нийтийн албан тушаалтандаа тооцогдох бөгөөд нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлзэг, бусад санхүүгийн туслалцааг хүсэхийг хуулиар хориглосон.

17.2. Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага албан үүрэгтэй нь холбогдолгүй гуравдагч этгээдээс үзүүлж байгаа нийтийн албаны хэрэгцээнд, ажилтны сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, техникийн дэмжлэг зэрэг албан тушаалтыг ашиг сонирхлын зөрчилд оруулахгүй хандив, бусад санхүүгийн туслалцааг энэ хуулийн 17.1-д заасан хязгаарлалтад хамаарахгүй бол авч болно.

Жишээ 33. Баянгол дүүргийн Засаг дарга дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг сургах, чадавхижуулах чиглэлээр хөтөлбөр батлав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт боловсрол олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Мэдлэг” төрийн бус байгууллагаас ажилтнуудад нь зориулсан сургалтыг үнэ төлбөргүй явуулах саналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргад тавьжээ. Тамгын газрын дарга үүнийг хүлээн зөвшөөрч, сургалтыг үнэ төлбөргүйгээр авчээ.

Энэ үлдэл хууль зөрчөөгүй байна.

17.3. Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна.



Жишээ 34. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга сургалтыг үнэ төлбөргүйгээр “Мэдлэг” төрийн бус байгууллагаас гаргасан санаачилгыг дэмжин явуулах болсноо Засаг даргадаа танилцуулан зөвшөөрөл авсан байв.

17.4. Энэ хуулийн 17.2-т заасан хандив, санхүүгийн туслалцаа авсан албан тушаалтан, төрийн болон нутгийн захирагааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хориглоно.

Жишээ 35. Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудыг сургах, чадавхижуулах хөтөлбөр ч амжилттай хэрэгжиж дууслаа. Жилийн дараа дүүргийн Засаг даргад хандаж, тухайн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах газар эзэмшиж зөвшөөрөл хүссэн албан бичиг “Мэдлэг” төрийн бус байгууллагаас ирсэн байхыг үзлээ.

Засаг дарга хууль зөрчин шийдвэр гаргахыг хүссэнгүй, хандив, санхүүгийн туслалцаа авсан тул хоёр жилийн хугацаанд хандивлагчтай холбоотой аливаа шийдвэр гаргахыг хуулиар хориглосон байдгийг танилцуулж ойлгуулсан байна.

17.5. Албан тушаалтан дараах тохиолдолд биечлэн, эсхүл бусад этгээдээр зуучлуулан хандив хүсэх, хандив цуглуулахад оролцох, хүлээн авахыг хориглоно:

17.5.1. хүнд өвчнийг эмчлэхэд шаардлагатайгаас бусад тохиолдолд өөртөө буюу өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хэрэгцээнд;

17.5.2. өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд нь ашиг хуваалцдаг иргэн болон хуулийн этгээдийн хэрэгцээнд;

17.5.3. өөртэй нь хамаарал бүхий этгээд нь удирдлага, хяналт, захирагааны албанад нь ажилладаг хуулийн этгээдийн хэрэгцээнд.



Жишээ 36. Дэд сайд Сүмбэрэл “Ноён оргил” сургуулийн удирдах зөвлөлийн даргаар ажилладаг. Сургуулийн захирал түүнээс нэр нөлөөгөө ашиглан сургуулийн 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардлагатай хандив цуглуулахыг хүсэхэд Сүмбэрэл ч зөвшөөрөв. Тэрээр сургуулийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд зориулан хандивын данс нээсэн тухай, өөрөө санаачилж 1 сая төгрөг хандивласан тухай зарыг олон нийтэд түгээв. Тэр байтугай хүлээн авалт, уран бүтээлийн тайлан тогтолц зохион байгуулж, ирсэн хандивыг өөрийн биеэр хүлээн авч байлаа.

Дэд сайд Сүмбэрэл хандив цуглуулах, хүлээн авах үйл ажиллагаанд биечлэн оролцсон нь хууль зөрчсөн үйлдэл болно. Хэрэв тэрээр хэн нэгэн өвчтэй хүнд туслах үүднээс хандивын аян өрнүүлсэн бол үүнд хориглох зүйл үгүй байв.

18 дугаар зүйл. Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалт

18.1. Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.



Жишээ 37. Долгор Боловсролын яаманд 18 жил ажилласан, салбарынхаа ажлыг арван хуруу шигээ мэддэг нэгэн. Тэрээр сүүлийн жилүүдэд сурх бичиг хэвлүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт ажиллаж байгаа. Өөрийн эзэмшсэн туршлага дээрээ үндэслэн Долгор “Үзэг - хаарандаа” хэвлэлийн компанийд орон тооны зөвлөхөөр давхар ажиллаж, сар бүр цалин авах болов.

Долгорын энэ үйлдэл нь түүнийг хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхэлж байгааг харуулах бөгөөд тэрээр хууль зөрчсөн гэж ойлгогдоно.

18.2. Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн дараах ажил, албан тушаалыг давхар эрхэлж болно:

18.2.1. хууль болон олон улсын гэрээгээр зөвшөөрсөн ажил;

18.2.2. нийтэд тустай үйл ажиллагаанд чиглэсэн ажил;

18.2.3. багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;

18.2.4. хуульд заасан бол өөр өөрийн чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын болон Засгийн газрын албан тушаал;

18.2.5. хууль тогтоомжоор зөвшөөрсөн олон улсын байгууллага дахь албан тушаал.

Жишээ 38. Улсын Их Хурлын гишүүн Хасбатдорж нь ядуурлыг бууруулах чиглэлээр “Амьдрах ухаан” сургалтын төв байгуулж, ядуу өрхийн гишүүдийг үнэгүй сургаж, чадавхижуулах үйл ажиллагааг явуулдаг. Түүний уг ажлыг давхар хашиж байгаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар иргэн Сувд Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороонд гомдол гаргажээ. Улсын Их Хурлын гишүүн хууль зөрчсөн үү?

Гомдолын дагуу холбогдох шалгалтыг хийж Улсын Их Хурлын гишүүн Хасбатдорж нь нийтэд тустай үйл ажиллагаанд чиглэсэн ажил эрхэлж байгаа нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг зөрчөөгүй гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

18.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан салбарын хуульд тусгайллан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно.

Жишээ 39. Баянзүрх дүүргийн прокурор Хишигтээ нь хууль тогтоомж зөрчиж Их засаг их сургуульд Эрүүгийн эрх зүйн хичээл заадаг тухай гомдлыг иргэн Эрдэнэбат гаргасан байна. Прокурор хууль зөрчсөн үү?

Дээрх гомдлыг эрх бүхий албан тушаалтан хянаж үзээд прокурор Хишигтээ нь Прокурорын байгууллагын тухай хуулиар зөвшөөрсөн багшлах ажлыг давхар эрхэлж байгаа нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг зөрчөөгүйг тогтоож, иргэн Эрдэнэбатад хариу өгсөн байна.

18.4. Зэвсэгт хүчиний албан тушаалтан өөрийн удирдах албан

тушаалтны бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэж, эрх эдэлж болно.

Жишээ 40. Ажлын бус цагаар Адмирал компанид гэрээгээр ажиллаж байсан Зэвсэгт хүчний ... дугаар ангийн сумангиин захирагч, ахмад Алтансүхийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зэрчлэөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн гэж сахилгын шийтгэл ногдуулж албан тушаал бууруулсан байна. Алтансүх уг шийдвэрийг үл зөвшөөрч тус ангид алба хаадаг ахмад Өлзий ч мөн өөр компанийд давхар ажил эрхэлж байгаад хариуцлага тооцохгүй ялгавартай хандаж байгаа талаар гомдол гаргасан байна.


Дээрх гомдлыг хянан үзээд ахмад Өлзий 3 сарын өмнө ангийн захирагчаас бичгээр зөвшөөрөл авсан тул хууль зөрчөөгүй, харин ахмад Алтансүх нь ангийн удирдлагад давхар ажил эрхлэх хүсэлтэй байгаагаа урьдчилан мэдэгдээгүй, бичгээр зөвшөөрөл аваагүй нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болсныг тайлбарласан байна.

18.5. Энэ хуулийн 18.2-18.4-т зааснаас бусад албан тушаалтан дараах ажлыг давхар эрхэлж болно.

18.5.1. хууль тогтоомж, олон улсын гэрээгээр болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн ажил;

18.5.2. багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажил;

18.5.3. ашиг сонирхлын зерчил үүсэхээргүй бол өөрийн удирдах албан тушаалтан, эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр бусад алба, гэрээний ажил, үүрэг.



Жишээ 41. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны мэргэжилтэн Дэлгэрийг эрх бүхий байгууллагаас “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчийт үйлдвэрийн газарт төрийн өмчийн төлөөлөгчөөр томилж, тэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болсон байна. Тэрээр төрийн өмчийн төлөөлөгчөөр ажилласны төлөө тогтоосон цалин хэлс авдаг юм.

Дэлгэрийн энэхүү үйлдлийг хуулиар хориглоогүй. Тэрээр эрх бүхий байгууллагаас албан ёсны төлөөлөгчөөр томилогдсон тул энэ ажлыг давхар эрхэлж болно.

18.6. Татварын албанад ажил, үйлчилгээ хувиараа эрхэлж байгаа гэж бүртгүүлсэн, жилийн орлого нь 10 сая төгрөгөөс хэтрэхгүй, эсхүл зөвхөн өрхийн хэрэгцээний төмс, хүнсний ногооны тариалан болон ойн аж ахуй, зөгий, загас, амьтан үржүүлэг, аялал, бусад сургалтын үйл ажиллагаанаас орлого олдог бол албан тушаалтан үүнийгээ давхар эрхэлж болно.

Жишээ 42. Төв аймгийн 10 дугаар сургуулийн захирал Бурмаа мод тарьдаг бөгөөд үүнээс бага бус орлого олдог.

Бурмааг ойн аж ахуй эрхлэх ажлыг давхар гүйцэтгэж болохыг хуулиар зөвшөөрсөн байна.

18.7. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалтыг хавсарч байгаа бол Улсын Их Хурлаас байгуулагдах хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орохыг, түүнчлэн хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлах, санал оруулахыг хориглоно.



Жишээ 43. Сампилбат нь Улсын Их Хурлын гишүүн бөгөөд Засгийн газрын гишүүн Сангийн сайдын албан тушаалыг хавсардаг. Сампилбат нь төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны явц байдал, холбогдох хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллаж байгааг шалгах зорилгоор Улсын Их Хурлаас хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлан, санал оруулах ёсгүй.

*Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн,
Сангийн сайд Сампилбат Улсын Их Хурлаас хяналт шалгалтын ажлын хэсэг байгуулахаар санаачлан, санал оруулах ёсгүй.*

19 дүгээр зүйл. Давхар ажил эрхлэхтэй холбогдсон хязгаарлалтыг хэрэгжүүлэх журам

19.1. Албан тушаалтан нийтийн албанад орох үед хуулиар зөвшөөрөөгүй өөр ажил, үүрэг, гэрээ гүйцэтгэж, эрх эдэлж байгаа бол энэ тухай дээд шатны албан тушаалтанд бичгээр танилцуулах үүрэгтэй.



19.2. Энэ хуулийн 19.1-д заасан танилцуулга хүлээн авсан албан тушаалтан ажлын байрны шаардлагыг харгалзан 30 хоногийн дотор давхар эрхэлж болохгүй алба, ажил, үүргээс чөлөөлөгдөх, гэрээ болон эрхийг цуцлах эсэх тухай шийдвэр гаргаж холбогдох албан тушаалтанд бичгээр мэдэгдэнэ.

Жишээ 44. Иргэн Баяр нь төрийн өмчит нэгэн компанид гадаад харилцаа хариуцсан орлогч захирлаар ажилладаг. Тэрээр дүүргийн Татварын хэлтэст гадаад харилцаа хариуцсан мэргэжилтнээр орсон бөгөөд ажилд орсон даруйдаа хэлтсийн дарга Доржид энэ тухай бичгээр танилцуулсан байна.

Хэлтсийн дарга Дорж хуульд заасны дагуу 30 хоногийн дотор давхар ажил эрхлэхээ зогсоох шийдвэр гаргахыг Баяарт мэдээгджээ.

20 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон хориглолт

20.1. Албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно.



Жишээ 45. Багануур дүүргийн Татварын хэлтсийн байцаагч Дэлгэрээгийн нийз Гарьд Япон Улсад мэргжил дээшлүүлэх сургалтад хамрагдан нэг жилийн хугацаагаар явах болов. Тэрээр нийз Дэлгэрээг өөрийн “Эн Эн Си Си” компанийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байх санал тавьсан боловч Дэлгэрээ саналыг хүлээж аваагүй байна.

Дэлгэрээгийн үйлдэл зөв. Нийтийн албан тушаалтны аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг гардан эрхлэхийг хуулиар хориглосон.

Жишээ 46. Иргэн Сүрэнхүү нэгэн арилжааны банкны гүйцэтгэх захибраар ажиллаж байсан. Тэрээр удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтад орж, улмаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилогджээ. Өмнө нь ажиллаж байсан банкийг өөрийн хөрөнгөөр босгосон тул эд хөрөнгөө бусдад даатгахыг хүсээгүй тул одоо банкныхаа удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа.

Сүрэнхүү аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллаж болохгүй. Тэрээр Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаа өгөх, эсхүл банкны удирдах зөвлөлийн гишүүнээс татгалзах ёстой.

20.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын дарга, Монгол Улсын Ерөнхий Аудитор, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Төрийн сангийн газрын дарга, тэдгээртэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэнсээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бурдуулэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг биелүүлж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй.



Жишээ 47. Улсын дээд шүүхийн шүүгч Өлзийжавын төрсөн дүү Буянжав “Хар алт” ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Уг компани төрөөс баталгаа гаргуулан Японы компаниас их хэмжээний зээл авсан байв. Буянжавын төрсөн ах Өлзийжавын эхнэр уг компанийн 6 хувийн хувьцаа эзэмшигч болов. Энэ талаар эхнэр нь Өлзийжавт хэлэхэд Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу өөрөө болон өөртэй нь хамаарал бүхий этгээд төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч байж болохгүй ойлгуулав.

Улсын дээд шүүхийн шүүгч Өлзийжавын эхнэр өөрийн эзэмшиж буй хувьцаагаа буцаан зарсан байна.

20.3. Энэ хуулийн 20.2-т заасан албан тушаалтан, түүнтэй хамаарал бүхий этгээд энэ зүйлд заасан үүргийг нийтийн албанаас чөлөөлөгдсөний дараа хоёр жилийн хугацаанд мөн биелүүлнэ.

Жишээ 48. Дээрх явдлаас хойш нэг жилийн дараа Өлзийжав тэтгэвэртээ гарчээ. Түүний эхнэр дүүгийнх нь компанийн хувьцааг одоо эзэмшиж болохоор болсон тул худалдан авах гэж байгаагаа хэлсэн байна.

Өлзийжав уг компанийн хувь эзэмшигч байж болохгүй тухай хуулийн заалтыг нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд биелүүлэх үүрэгтэйг эхнэртээ тайлбарлан ойлгуулсан байна.

20.4. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтан тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглоно.



Жишээ 49. “Уурхай” төрийн өмчит компани аюулгүй байдлаа хангахад зориулсан галын хор худалдан авах тендер зарлахад “Зуунжил” компани шалгарч галын хор нийлүүлэхээр болжээ. “Уурхай” компанийн гүйцэтгэх захирал Палам “Зуунжил” компаниас нийлүүлэх гэж буй галын хорын үнийн дүнгийн 10 хувийг өөртөө ашиг болгон авахыг хүсэхэд нийлүүлэгч компани зөвшөөрсөн байна

Гүйцэтгэх захирал Палам тухайн хуулийн этгээдэд нийлүүлэх төрийн болон орон нутгийн хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалгын нийлүүлэгчээс ашиг авахыг хориглох хуулийн заалтыг зөрчсөн байна.

20.5. Албан тушаалтан нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авахыг хориглоно.



Жишээ 50. Иргэн Бархас дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргаар ажиллаж байгаад албан тушаалаасаа чөлөөлөгджээ. Түүний эхнэр нь “Хайрхан” компани их ашигтай ажиллаж байгаа, тэдний хамтрагч болохыг зөвлөв. Гэвч Бархас энэ зөвлөгөөг хулээн авсангүй.

Учир нь Бархас дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн даргаар ажиллах хугацаандаа Хайрхан компанийн үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийн хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргаж байжээ. Иймд Хуулийн 20.5-д заасны дагуу тэрээр нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа хянах, хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргаж байсан “Хайрхан” компанийн хамтрагч байх боломжгүй юм.

21 дүгээр зүйл. Албан тушаалаас чөлөөлөгдсөний дараах хязгаарлалт

21.1. Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

21.1.1.урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;

21.1.2.урьд ажиллаж байсан байгууллагатай гэрээ, контракт байгуулах, тухайн байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх;

21.1.3.урьд ажиллаж байсан байгууллагын өмнө аливаа хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөх.

Жишээ 51. Авто замын газрын дарга Данзан нь 6 сарын дараа тэтгэврийн насанд хүрэх бөгөөд ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийж тэтгэвэрт гарангуутаа гүйцэтгэх захирлаар ажиллах болзолтойгоор Мянганы замын төсөлд ажиллаж байгаа “Оддын зам” нэرتэй компанийт шууд гэрээ байгуулан хэд хэдэн ажлыг гүйцэтгүүлэв.

Данзан тэтгэвэрт гарсны дараа “Оддын зам” компанид гүйцэтгэх захирлаар ажиллах ёсгүй. Данзан албан үргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь ашиг сонирхлын зөрчил үүсч болох холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллахыг хориглоно.

Жишээ 52. Дорж цагдаагийн тусгай хэлтэст 20 жил ажиллаж байгаад өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөв. Тэрээр дөрвөн сарын дараа “Зоригт эрс” хэмээн хамгаалалтын албыг байгуулан хамгаалалтын албаны гэрээт харуул ажиллуулах зөвшөөрлийг өмнө ажиллаж байсан байгууллагын хэлтсийн даргаасаа хүсчээ.

Албан тушаалтан ажлаасаа чөлөөлөгдсөний дараа урьд ажиллаж байсан байгууллагаас олгодог зөвшөөрлийг хүсэх ёсгүй. Дорж Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2-т заасныг зөрчжээ.

21.2. Энэ хуулийн 21.1.2-т заасан хязгаарлалт нь тухайн этгээд албан тушаалд сонгогдож, томилогдооос өмнө байгуулагдсан буюу сунгагдсан гэрээ, контракт, түүнчлэн нээлттэй тендер шалгаруулалтын дагуу байгуулагдсан, эсхүл жилд долоон сая төгрөгөөс бага үнийн дүн бүхий гэрээ, контрактад хамаарахгүй.

Жишээ 53. Цэрмаа Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд зочид буудлын үйлчилгээний тусгай зөвшөөрөл, бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтнээр ажиллаж байгаад өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөхөд “Дөрвөлжин өргөө” зочид буудлын гүйцэтгэх захирлаар ажиллах санал ирэв. Тэрээр ашиг сонирхлын зөрчилд өртсөн гэх хэл аманд орох вий хэмээн болгоомжилж, яаманд ажиллаж байх үедээ бэлтгэж, боловсруулсан болон гардан хэрэгжүүлсэн шийдвэрүүдийн жагсаалтыг он, сар, өдрөөр нь нэгбүрчлэн гаргажээ. Түүнчлэн “Дөрвөлжин өргөө” зочид буудлын тусгай зөвшөөрөл, гэрээний огноог ч жагсаан гаргав. Жагсаалтаас харахад Цэрмааг гүйцэтгэх захирлаар томилогдооос 3 сарын өмнө тусгай зөвшөөрөл сунгагдсан байх ажээ. Тиймээс Цэрмаа “Дөрвөлжин өргөө” зочид буудлын гүйцэтгэх захирлаар ажиллахыг зөвшөөрчээ.

Үг саналыг хүлээж авсан тохиолдолд Цэрмаа хууль зөрчихгүй. Учир нь Цэрмааг зочид буудлын гүйцэтгэх захирлаар томилогдооос өмнө гэрээ сунгагдсан байна.

21.3. Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй албаны чиг үүргийн дагуу харилцаа тогтоохыг хориглоно.



Жишээ 54. Цэрмаа урьд хамт ажиллаж байсан Дулмаагаас зочид буудлын менежментийн талаар зөвлөгөө авах, яамнаас зочид буудлуудад хийх хяналт шалгалтын талаар санал солилцооор түүнтэй уулзах хүсэлт тавьсан байна.

Цэрмаагийн ажиллаж байсан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтэн Дулмаа Цэрмаатай албаны чиг үүргийн дагуу харилцаа холбоо тогтоох ёсгүй.

21.4. Албан тушаалтан энэ хуулийн 21.1-д заасан хязгаарлалт зөрчигдэж байгаа талаар эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

Жишээ 55. Дулмаа урьд хамт ажиллаж байсан Цэрмаатай уулзжээ. Гэвч Дулмаа хуулиар өөрт тавигдаж буй хязгаарлалтыг тайлбарлан албан ажлын талаар ярихгүй байхаар тохиролцсон боловч зарим албаны чиг үүргийн чанартай асуудлаар санал солилцсон байна.

Яамны мэргэжилтэн Дулмаа хуульд заасан хязгаарлалтыг зөрчжээ.

22 дугаар зүйл. Бусад орлогын хязгаарлалт

22.1. Албан тушаалтан өөрийн албан үүргийн дагуу авах цалин хөлснөөс гадна энэ хууль, бусад хуулиар хориглоогүй бусад ажил, алба, гэрээний урамшуулал, мөн хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааны орлого олж болно.

Жишээ 56. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэргэжилтэн Дондог удирдлагаас өгсөн үүргийн дагуу “Малын удмын сангийн төрлийг нэмэгдүүлэх нь” чиглэлээр төслийн зөвлөхийн үүрэг гүйцэтгэсэн байна. Төсөл амжилттай хэрэгжиж дуусахад Дондогт төслийн зохицуулагч зөвлөхөөр ажилласны урамшууллыг олгосон байна.

Дондогийн үйлдэл хууль зөрчөөгүй байна.

22.2. Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа бол Засгийн газрын гишүүний цалин авна.

22.3. Албан тушаалтан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа болон ажил үүрэг гүйцэтгэхээ больноос хойш хоёр жилийн хугацаанд дараах үйл ажиллагааг хориглоно:

22.3.1. шууд, эсхүл гуравдагч этгээдийн зуучлалаар ажил, үүрэгтэй нь холбоогүй санхүүгийн эх үүсвэр зэрэг аливаа үр ашиг хүлээн авах;

22.3.2. холбогдох төрийн өмчит хуулийн этгээд болон түүний удирдлага, захиргааны гишүүнээс бэлэг авах;

22.3.3. холбогдох төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаас, хөрөнгө олж авах;

22.3.4. холбогдох төрийн өмчит хуулийн этгээдэд өөр албан тушаал эрхлэх.



Жишээ 57. Төрийн өмчийн оролцоотой “Агуй” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсон төрийн өмчийн төлөөлөгч Болд нь төрийн жинхэнэ албан хаагч бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлд 3 жил ажиллаж байгаад чөлөөлөгджээ.

а. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл хуралдаад түүнд уг компаниас гарган худалдаж буй бондоос 100 ширхгийг бэлэглэхээр шийдвэрлэсэн байна. Төрийн жинхэнэ албан хаагч Болд хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.2-т заасныг үндэслэн уг бэлэгнээс татгалзсан.

б. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс чөлөөлөгдсөнөөсөө хойш Болд нь хоёр жилийн турш төрийн албанад үүрэгт ажлаа үргэлжлүүлэн хийж байгаад өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдж, ганц гишүүнтэй “Жимс” ХХК-ийг байгуулан үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Түүний компани шинэ технологи нэвтрүүлж, зах зээлд худалдан авагчтай болж эхлэхэд “Агуй” ХК “Жимс” ХХК-ийг худалдан авах санал тавьжээ. Болд зөвшөөрсөн бөгөөд төлбөрийн оронд “Агуй” ХК-ийн хувьцааны тодорхой хэсгийг эзэмших, мөн уг компанийн гүйцэтгэх удирдлагад ажиллах болзول тавив. Хуулийн 22 дугаар зүйлийн 22.3-т заагдсан хоёр жилийн хугацаа өнгөрсөн байсан тул “Агуй” ХК үүнийг зөвшөөрөх боломжтой юм.

